МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009

Зөв зүгт манлайлна



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН ТОВХИМОЛ

2025 ОН

01-р сарын тайлан



Монгол Улс, Улаанбаатар 15141,
Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Самбуугийн гудамж,
МН Тауэр, 8-р давхар, 805, 806, 811 тоот

7011 1515

info@mnca.mn

www.mnca.mn


JIGUUR GRAND GROUP
МАКС ӨРГӨӨ
TSAST for clean life
Royal New Castle
ultrasonic
NCD
NBTK
ZAG GROUP
BASALTWOOL
ERELT IMPEX
MCS property LLC
БУТИ
UGUUJ KHISHIG CO.,LTD
T&G GREEN RESOURCE
SD ENGINEERING & CONSTRUCTION
ERIN INTERNATIONAL
ERCHIM ENGINEERING LLC
ChMM construction
SERUUN SINCE 1991
БАТС-ӨРГӨӨ ХХК
MONCON MONGOLIAN CONSTRUCTION GROUP
barilga.mn
БУЯНПЭЛ ХХК
БАРМОН
RENDERBAU
BRIDGE CONSTRUCTION
TESO
DYNAMIC TOWER
VIP RESIDENCE
UNISTEEL CONSTRUCTION
SKETCH LLC
EFES CONSTRUCTION
ТУМ АРВИЖИХ
БОДЬ ИНТЕРНЭШНЛ
GR PRECAST CO.,LTD
InvesCore PROPERTY LLC
BDMT
СҮНДЭР ОРГӨӨ ТРЕЙД ХХК
ОФФИС ПАРТНЕР
HIMON
DOBU
ТАВАН БОГА ПРОПЕРТИ ХХК
АЛТАН ЖОЛОО КОНСТРАКШН
BAGANAT URGUU COMPANY
HYUNDAI ХЬЁНДЭ ЭЛЕВАТОР МОНГОЛ ХХК
ТОПОЛОГИ ХХК
ЭРЧИМ ХУЧ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ДЭД БҮТЭЦ
NEW TELECOM
RENDER TRADE
Ecological Civil Construction
ProHeat Heating & Construction
ХУРД ГРУПП
ТЭНХЛЭГ ЗУУЧ
УЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН КОМПАНИ
GLOBAL TELECOM
БАЗУРА ДИЗАЙН
N.A.P GROUP
MINES UP
UB GROUP
EUROZIGI ENGINEERING Co.,Ltd
АРГАЛАНТ АРВИС ГРУПП
SOYOLON ENGINEERING
НОМИН ХИШЭЭ
ХАЙРХАН ГРУПП
MCS estates
ЦАГААН УРИЙ ХИЙЦ
"БОДЬ ЦОГТ" ХХК
"AGGS" LLC
BUTANGUUD CONSTRUCTION LLC
PD Solutions LLC
МОНГОЛ АЛТАЙН ЦАГ
HOME MORTGAGE CORPORATION
ULAANBAATAR PROPERTIES
BULDOORS MON PERFECT DOOR SOLUTIONS
НУТГИЙН БУЯН ГРУПП ХХК
МИШЭЭЛ ГРУПП
Смарт Грийн Девелопмент
GLOBAL ELECTRONICS
GOLDEN LIGHT GROUP
INTERNATIONAL
АЛХ ХАДААС ХХК
ХАНГАЙН ИЛЧ ДУЛААН ХХК
БАЯНСҮНДЭРЭЛ
ЭВЭР ТУУРАЙ
BOLD
daco
IG CON ENGINEERING CONSULTANTS
ИНК ИНСТАЛЛ НАРАН КОНСТРАКШН
"АТИМОС ТРЕЙД" ХХК
eGO ENGINEERING & CONSTRUCTION
MONGOL 323 CORPORATION
РАДИУС ХХК
ЦАГААН ХӨШӨӨ ТРЕЙД
SILVER TOWER
Oortsog-Uul
ГУРВАН БУХАТ ГРУПП
ИМ ИХ МОДНЫ ХХК
A1 ARCHITECTS
MANDALT CONSTRUCTION Co.,Ltd
АССЭ ХХК
CHOKWANG CHOKWANG PAINT
ENDLESS energy
ZINDAA CONSTRUCTION
O&OCH LLC
NATIONAL CONSTRUCTION CONSULTING SERVICES
HAPPY BUILDING LLC
RICHWELL ENGINEERING LLC
RE/MAX STAR
DKH
ДЭЛГЭРЭХ ТАВАН ЧАНДМАНЬ ХХК
VISION DEVELOPMENT LLC
ГАНЬТ CONSTRUCTION AND TRADING
ОРГИЛ ЖИЙР
ХАРХОРИН - ОРГӨӨ ХХК
LegalLink
NOMAD'S ROAD
MPI consultants
PETROLEUM CONSULTING & ENGINEERING
SATRADE
NAB GROUP NATIONAL ADVANCED BUSINESS
TML
MIRC CONCRETE
PARCO FACADE LLC

ОРШИЛ

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ нь өөрийн байгууллагын Эрхэм зорилго, зорилтын хүрээнд зах зээлийн эдийн засгийн үндсэн зарчимд нийцсэн барилгын салбарын тогтвортой байдлыг хангах, засаглалын зөв тогтолцоог бий болгох, салбарын эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг хангасан урт, богино хугацааны бодлогын болон стратегийн бичиг баримтыг боловсруулахад нөлөөлөх, суурь судалгааг хийх, салбарын чадавхыг сайжруулах чиглэлд салбарын яам, холбоод, иргэний нийгэм, гадаадын төсөл, хөтөлбөр болон олон улсын байгууллагуудтай үйл ажиллагаагаа өргөжүүлэн олон талаар хамтран ажилладаг билээ.

Дээрх эрхэм зорилго, зорилтын хүрээнд МБҮА ТББ-ын Ажлын алба нь 2025 оны 01 дүгээр сард хийж гүйцэтгэсэн ажил, арга хэмжээ, үйл ажиллагааныхаа тайланг товхимол хэлбэрээр бэлтгэн хүргэж байна.

ОЛОН НИЙТЭД ЗОРИУЛСАН ТАЙЛАН

2025

АГУУЛГА



1. ЗАХИРГАА УДИРДЛАГА
2. БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГАА
3. СУРГАЛТ, ХӨГЖИЛ
4. ГИШҮҮНЧЛЭЛ ХАМТЫН АЖИЛЛАГАА
5. БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
6. ДУЛААН ШИЙДЭЛ ТӨСӨЛ-2

2025



ЗАХИРГАА-УДИРДЛАГА

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ нь 2009 онд үүсгэн байгуулагдаж, өөрийн эгнээндээ барилга, бүтээн байгуулалтын салбарт идэвхтэй үйл ажиллагаагаа явуулдаг томоохон хөрөнгө оруулагч, хөгжүүлэгч, үл хөдлөх хөрөнгийн реалтор, барилга угсралт, барилгын материалын үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч, архитектур, зураг төслийн чиглэлийн 160 гаруй гишүүн компаниудын бүтээн байгуулагчдыг сайн дурын үндсэн дээр нэгтгэж, гишүүддээ болон нийгэмдээ үйлчлэхээс гадна төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэдэг салбарын мэргэжлийн, манлайлагч, үндэсний бүтээн байгуулагчдын хамгийн том нэгдэл болох төрийн бус байгууллага юм. МБҮА ТББ нь Азийн ба Баруун Номхон Далайн Гэрээлэгчдийн Ассоциациудын Олон Улсын Нийгэмлэг (IFAWPCA)-ийн “УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН”, Олон Улсын Зөвлөх Инженерүүдийн холбоо (FIDIC)-ны “ТҮНШЛЭГЧ ГИШҮҮН”, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим (МҮХАҮТ)-ын УДИРДАХ ЗӨВЛӨЛ БОЛОН ТЭРГҮҮЛЭГЧ ГИШҮҮН” байгууллага юм.

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР 15141,
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, 5-Р ХОРОО, САМБУУГИЙН ГУДАМЖ
МН ТАУЭР, 8-Р ДАВХАР
WWW.MNCA.MN

НИЙСЛЭЛИЙН ТҮГЖРЭЛИЙГ ШИЙДЭХ ЗУРГААН БАГЦ ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ ЭХЭЛНЭ



Нийслэл Улаанбаатар хот нь өнөөдрийн байдлаар байнгын оршин суугч 1,650,000 хүн, ирж очиж байгаатайгаа нийлээд 2 сая хүн тогтмол амьдардаг томоохон хотуудын нэг болж түүнээс үүдсэн авто замын түгжрэлийн асуудал хүн бүхний хувьд асуудал болоод байгааг та бүхэн мэдэж байгаа. Уг асуудлыг шийдэх хүрээд Нийслэл Улаанбаатар хотын Авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн захирал У.Баатар түгжрэлийг бууруулахад авч хэрэгжүүлж буй төслүүдийн талаарх мэдээллээ танилцууллаа. Нийслэлд 2030 он гэхэд метро, дүүжин тээвэр, LRT, BRT, тойрог хурдны зам, туулын хурдны замын төслүүдийг ашиглалтад оруулах зорилт тавьсан. Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжээс, төслүүдийг хэрэгжүүлэх он цагийн дагуу судалгаа, шинжилгээ, тооцоолол, ажлуудыг хийж бэлтгэл ажлуудыг хангаж байгаа. Туулын хурдны зам төсөл нь инженерийн шийдлийн хувьд авч үзвэл хоёр жилийн хугацаанд барих боломжтой. Тус замын байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл судалгаагаар харагдана. Голын голдирол, одоо байгаа ногоон байгууламж, ойр орчинд нь амьдарч байгаа ан амьтны нүүдэл гэхчлэн олон асуудал бий. Томоохон төслүүдийг хэрэгжүүлэхийн тулд бид Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамтай хамтарч ажиллаж байгаа. Ажлын хэсэгт төлөөллүүд орж, чиглэл бүрийн асуудлыг авч хэлэлцэж байгаа. Мөн хэрэгжиж байгаа төслүүдийнхээ явцыг иргэд олон нийтэд ойлгомжтой байлгах үүднээс **ipiu.mn** сайтад дэлгэрэнгүй харуулахаар төлөвлөж байгаа. 14 хоногийн дараа хөгжүүлэлт дуусах учраас хүссэн иргэд төслүүдийн ерөнхий мэдээллийг орж харах боломжтой.Дүүжин тээвэртэй холбогдох судалгааг хийж, шаардлагатай техник хэрэгслийг татан авах талаар холбогдох улс орнуудын нийлүүлэгчидтэй уулзсан. Үнэ ханш болон зээлийн тухайд Монголын талд ашигтай байхаар харж байгаа. Одоогоор дүүжин тээврээр зорчих үнэ эцэслэгдээгүй. Улирал тутамд л бид ТЭЗҮ дээрээ анализ хийж, үнийн хэлбэлзлийг тооцоолж байгаа. Эцсийн дүндээ бол байж болох хамгийн хямд үнээр л иргэд зорчих боломжийг бүрдүүлнэ. Хамгийн гол нь иргэн бүр суух боломжтой, төлж чадах тарифыг л тогтооно. Тоног төхөөрөмжүүд эхнээсээ Замын-Үүдийн боомтоор орж ирж байгаа. Ирэх оны зургаадугаар сард үндсэн цамхаг, кабинаа угсрах ажлаа хийж дуусна. Дүрмээрээ угсралт хийснээс хойш бүтэн зургаан сар, зорчигч суулгалгүй туршилтын тээвэрлэлт хийх ёстой. Бид энэ цаг хугацааг нь наашлуулж, ирэх оны есдүгээр сарын 1-ээс өмнө Улсын комисс хүлээж авах шаардлагыг тавьж байгаа. Нийслэлийн зүгээс зөвшилцөх бүх ажлаа хийж дуусгасан. Одоо газар чөлөөлөлтийн ажил "Хархорин" худалдааны төвийн баруун талд байдаг "Барс-2″ худалдааны төвийн зарим хэсгийг буулгана. Мөн хажуугийн нэг объектыг буулгана. Бид өмчлөгч иргэдтэй тохиролцсон байгаа. Яармагийн зам дээр оргил ачааллын үед 90-95 мянган машин зорчиж байна. Энэ том урсгалыг сааруулах зорилготойгоор энэ төслийг хийж байгаа" гэж байсан юм.Мөн трамбай төсөл, нүхэн гарц төсөл, тусгай хэрэгцээний автобус төсөл, метро төслүүдийн өнөөгийн явц, хэрэгжилтийн талаарх мэдээллийг дэлгэрэнгүй өгч уг бүтээн байгуулалтыг хийхэд Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ, Монголын Инженерүүдийн Холбоо ТББ-ын гишүүн байгууллагуудтай хамтран ажиллахаар болсон талаар дурдсан юм.

АТГ-ААС БАРИЛГЫН САЛБАРЫН ТББ, КОМПАНИУДАД АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙГ ӨГЛӨӨ





“Барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, барилгын ажлыг гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээг эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрлийг олгох” үйл ажиллагааг БХБ-ын сайдын тушаалууд болон БХБЯ-тай байгуулсан гэрээнүүдийн үндсэн дээр МБҮА ТББ нь салбарын бусад мэргэжлийн ТББ-уудын түншлэлийн хамтаар 2018 оноос эхлэн амжилттай гүйцэтгэж, 2021 оноос бүрэн цахимжуулж, 2023 онд “БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ОЛГОХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ” үйл ажиллагааг БХБ-ын сайдын 2023.05.30-ны өдрийн 131-р тушаалаар хоёр жилээр сунган үргэлжлүүлэн гүйцэтгэж байгаа билээ. Одоогоор цахим систем нь төрийн ХУР, ДАН, И-МОНГОЛ, НДЕГ, БСШУЯ-ны цахим платформуудтай холбогдсоноор Монгол Улсын тогтолцоо, хууль эрх зүйн ба бизнесийн орчныг боловсронгуй болгож, хүнд суртал, авлигатай тэмцэх зорилтын хүрээнд цахим, ил тод, нээлттэй, хүнээс хараат бус тогтолцоог нэвтрүүлэн ажиллаж байна. Төрийн чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэдэг МБҮА ТББ-ын Ажлын алба, Гишүүн байгууллагуудын дунд АТГ-ын Соён гэгээрүүлэх газраас Барилгын салбарын ТББ-ыг чадавхжуулах сургалтын хүрээнд тус газрын УССГХ-ийн дарга, эрхэлсэн комиссар Х.Ихмөрөн, комиссар А.Тунамал-Эрдэнэ, комиссар С.Баярцэцэг нар АТГ-ын танилцуулгыг хийж улмаар Авлигын шалтгаан нөхцөл хор хөнөөл юунд хүргэдэг талаарх мэдээллийг өгөхөөс гадна барилгын тусгай зөвшөөрлийг олгоход гарч байгаа хүндрэл бэрхшээл, түүнийг тойрсон гомдол мэдээллүүд, улсын төсвийн хүрээнд гүйцэтгэж буй барилга байгууламжийн чанар, тендер, худалдан авалт, улсын комисс хэрхэн хүлээж авдаг талаарх мэдээллүүдийг статистик, тоо баримт, бодит кейс дээр үндэслэн танилцуулга хийлээ. Улмаар “Барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, барилгын ажлыг гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээг эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрлийг олгох” үйл ажиллагааг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж буй МБҮА ТББ-ыг АТГ-тай хамтран ажиллах, гарч буй гомдол мэдээллийн талаар тухай бүр харилцан мэдээлэл солилцох, зөвлөмж мэдээллээр хангахад нээлттэй байхаа илэрхийллээ.

МНХ-НЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ ХЭРЭГЖҮҮЛЭХ БЭЛТГЭЛ ХАНГАХ АЖЛЫН ХЭСГИЙН ХҮРЭЭНД

МНХ-ны хуулийн ажлын хэсгээс гарсан саналын дагуу МБҮА ТББ-ын үйл ажиллагааны чиглэлд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа "Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал"-д заасан “9411 – барилгын бизнесийн үйл ажиллагааг хөгжүүлэх, дэмжих чиглэлд ашиг сонирхол нийлсэн тодорхой бүлгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажил олгогч байгууллагуудын нэгдэл, ассоциаци, холбооны үйл ажиллагаа”; “9412 - Мэргэжлийн гишүүнчлэл бүхий байгууллагын үйл ажиллагаа болон барилга угсралт, барилгын инженерчлэл, барилгын тусгай, төрөлжсөн үйл ажиллагаа явуулдаг гишүүн байгууллагуудын шинжлэх ухаан, мэргэжил эсвэл техникийн чиглэлээрх эрх ашгийг хамгаалах үйл ажиллагаа” гэсэн 2 төрлийн үйл ажиллагаа нэмж бүртгүүлэхээр УБЕГ-т албан бичиг хүргүүллээ.

2025



САЛБАРЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР 15141,
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, 5-Р ХОРОО, САМБУУГИЙН ГУДАМЖ
МН ТАУЭР, 8-Р ДАВХАР
WWW.MNCA.MN


Салбарын бодлого, төлөвлөлтийн чиглэлээр:

- Стандарт хэмжил зүйн газарт 2025-2026 оны стандартчиллын хөтөлбөрт санал бэлтгэж хүргүүлсэн.
- Мөн “Худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий орон сууцны зураг төслийн стандарт”, “Ногоон барилгын стандарт” гэсэн стандартуудыг шинээр боловсруулж батлуулах шаардлагатай гэж үзэж байгаагаа илэрхийлсэн саналыг Норм, нормативын сангийн 2025 оны төлөвлөгөөнд тусгуулахаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яаманд хүргүүллэ
- МБҮА ТББ-ын дэргэд Барилга, дэд бүтцийн арбитр байгуулах ажлын зөвлөх үйлчилгээ, ФИДИК-ийн орчуулгын ажлын явцын талаар мэдээллийг 2025 оны УЗ-ийн анхдугаар хуралдаанаар мэдээлэл сонсохоор УЗХ-ын төлөвлөгөөнд тусгаад байна. МБҮА ТББ-ын дэргэд мэргэжлийн зөвлөх үйлчилгээний баг байгуулах зорилгоор Гүйцэтгэх захирлын 2025.01.09-ний өдрийн Б/04/25 дугаар тушаалаар баталсан шинэчлэгдсэн бүтцэд салбарын бодлогын гэрээт зөвлөхийн нэгжийг оруулан батлав.
- Мэргэжлийн нэгдсэн холбоо байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгээс гарсан саналын дагуу МБҮА ТББ-ын үйл ажиллагааны чиглэлд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа "Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал"-д заасан “9411 – барилгын бизнесийн үйл ажиллагааг хөгжүүлэх, дэмжих чиглэлд ашиг сонирхол нийлсэн тодорхой бүлгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажил олгогч байгууллагуудын нэгдэл, ассоциаци, холбооны үйл ажиллагаа”; “9412 - Мэргэжлийн гишүүнчлэл бүхий байгууллагын үйл ажиллагаа болон барилга угсралт, барилгын инженерчлэл, барилгын тусгай, төрөлжсөн үйл ажиллагаа явуулдаг гишүүн байгууллагуудын шинжлэх ухаан, мэргэжил эсвэл техникийн чиглэлээрх эрх ашгийг хамгаалах үйл ажиллагаа” гэсэн 2 төрлийн үйл ажиллагаа нэмж бүртгүүлэхээр УБЕГ-т албан бичиг хүргүүлсэн бөгөөд ТББ-ын дүрмээ шинэчлэн эдгээр үйл ажиллагааг нэмж тусган, УЗ-ийн хурлын тогтоол гаргуулж өөрчлөлт хийлгэхийг зөвлөсөн болно.

Судалгааны ажлын чиглэлээр:

- МБҮА ТББ-ын Ажлын албаны 2025 оны 1-р сарын үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд 2025.01.02-31-ний өдрүүдэд ажил үүргийн хуваарийн дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: Паркетан шалны импортын мэдээлэл бэлтгэж, Гүйцэтгэх захиралд танилцуулав.
- “Хятад болон Монгол улс дахь хөдөлмөрийн шилжилт хөдөлгөөн” судалгааг Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын вэб хуудаснаас тоймлон орчуулж бэлтгэн танилцуулав.
- “Дэлхийн барилгын салбарын 2025 оны топ 10 чиг хандлага” мэдээлэл бэлтгэн барилга.мн сэтгүүлд өгч байгууллагын тусгай булантай болж байна.
- МБҮА ТББ-ын гишүүн АГГС ХХК (AGGS)-д “Барилгын материалын үйлдвэрлэлийн судалгаа” бэлтгэн хүргүүлсэн.
- “Барилгын салбар дахь албан бус хөдөлмөр эрхлэлт” судалгаа бэлтгэж байна.

2025



БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР 15141,
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, 5-Р ХОРОО, САМБУУГИЙН ГУДАМЖ
МН ТАУЭР, 8-Р ДАВХАР
WWW.MCIS.GOV.MN

“ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ: ӨӨРЧЛӨЛТ ШИНЭЧЛЭЛТ”-ИЙН ХҮРЭЭНД “АЖЛЫН ХЭСЭГ” САНАЛАА СОЛИЛЦЛОО



2024.11-р сард "ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ: ӨӨРЧЛӨЛТ ШИНЭЧЛЭЛТ-2024" олон нийтийн хэлэлцүүлэг, нээлттэй өдөрлөгт 118 аж ахуй нэгж байгууллага оролцож, санал хүсэлтээ холбогдох албаныханд хүргүүлсний дагуу Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын Сайдын 2024.12.16-ны 126 дугаар тушаалаар байгуулагдсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материал үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл угсралт засвар үйлчилгээний хөлс тогтоох, хяналт тавих журмыг шинэчлэн боловсруулах" ажлын хүрээнд ажиллах Ажлын хэсгийн ээлжит хурал 2025.01.07-ны өдөр ХБХОСЯ-ны хурлын танхимд боллоо. Энэ удаагийн хурлаар Ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудтай танилцахын зэрэгцээ цаашид хэрхэн хамтарч ажиллах талаар санал солилцлоо.

БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХТОЙ ХОЛБООТОЙ ТӨРИЙН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ТҮНШЛЭГЧ ТББ-УУДЫН УДИРДЛАГУУДЫН 2025 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ХИЙЛЭЭ



МБҮА ТББ нь салбарын мэргэжлийн ТББ-ууд болох “МБЗТЗХ” ТББ, “МБГБХ” ТББ, “МБИХ” ТББ, “ӨТМТҮХ” ТББ, “БТХ” ТББ, “МБИГХ” ТББ зэрэг түншлэгч байгууллагуудтай хамтран барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд өнөөдөр буюу 2025.01.03-ны өдөр түншлэгч ТББ-уудын удирдлагуудын ээлжит хурлыг зохион байгууллаа. Хурлаар ХБХОСЯ-аас Сайдын 126 тушаал гарсантай холбоотойгоор түншлэгч байгууллагуудын байр суурь, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох ажлын төрөл, суурь нөхцөлд шаардлагад оруулах саналын талаарх хэлэлцэх юм. Мөн 2025.01.24-ны өдөр Түншлэгч байгууллагуудын удирдлагуудын хурлыг зохион байгуулав. Хурлаар Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг Ажлын албаны БҮАТЗХ-ийн дарга Э.Мөнгөнхундага, Санхүүгийн 2024 оны үйл ажиллагааны тайланг Ажлын албаны Нягтлан бодогч О.Мөнхчимэг нар танилцуулав. Тус хурлаар Барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, барилгын ажлыг гүйцэтгэх, өргөх байгууламж түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллагатай байгуулсан гэрээний биелэлтийг хэлэлцүүлэх, хэрэгжилтэд хяналтыг тавьж, үр дүнг танилцуулах, цаашид хийх ажлын талаар хэлэлцэв.

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖЛЫН ТӨРӨЛ, СУУРЬ НӨХЦӨЛ ШААРДЛАГЫГ АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД ХҮНДРЭЛГҮЙ, ЧИРЭГДЭЛГҮЙ БАЙХ ТАЛ ДЭЭР ШИНЭЧЛЭН НАЙРУУЛАХААР АЖИЛЛАЖ БАЙНА



Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тавих нөхцөл, шаардлага болон үйлчилгээний

хөлс тогтоох, хяналт тавих журмыг шинэчлэн боловсруулахаар Хот байгуулалт барилга, орон сууцжуулалтын сайдын 126 дугаар тушаалын дагуу байгуулагдсан “Ажлын хэсэг”-т МБҮА ТББ оролцож ажиллаж байгаа бөгөөд уг ажлын хүрээнд 2025.01.14-ны өдөр бусад ТББ болон ААНБ-ууд болоод Гишүүн байгууллагуудын саналыг сонсох уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтад Монгол Улсын Гавьяат барилгачин Л.Шагдаррагчаа тусгай зөвшөөрлийн суурь нөхцөл шаардлагыг Зөвшөөрлийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Ашиг сонирхлын зөрчлийн хууль, Барилгын тухай хууль зэрэг бусад хууль дүрэмтэй хэрхэн зохицуулж шинэчлэх болоод цаашид Тусгай зөвшөөрлийг орчин үеийн шаардлагад хэрхэн нийцүүлэх талаар өөрийн санал бодлоо солилцлоо. Мөн МБҮА ТББ-ын гишүүд болох Ультрасоник ХХК-ийн захирал Б.Чимэгцэцэг, Эрчим инженеринг ХХК-ийн захирал М.Батболд, АНэг компанийн захирал Г.Мөнхжаргал, Эрэлт импекс ХХК-ийн захирал Д.Энхтөр болоод бусад гишүүд саналаа өгч журмыг цаг үеийн шаардлагад нийцүүлж аж ахуйн нэгжүүдэд хүндрэлгүй, чирэгдэлгүй болгоход анхааран ажиллах талаар саналаа солилцлоо.

БҮАТЗ-ИЙН ГЭРЧИЛГЭЭГ ГАРДУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ БОЛЛОО



МБҮА ТББ нь барилгын төсөл хөгжүүлэгчид, гүйцэтгэгчид, гэрээлэгчид, архитектур, зураг төсөл зохиогчид, барилгын ханган нийлүүлэгчид, зөвлөх үйлчилгээний компаниуд, материал үйлдвэрлэгчид, үл хөдлөх хөрөнгийн борлуулалтын зэрэг 200 орчим гишүүн компаниудаас бүрдсэн барилгын салбарын томоохон ТББ бөгөөд мөн Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг олгох үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг салбарын ТББ-уудтай хамтран хэрэгжүүлдэг билээ. Энэ ч үүднээс энэ жилээс барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг иргэд аж ахуйн нэгж авахад гарч буй хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх, журамд өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийн заалтыг хөнгөвчлөх тал дээр салбарын яамтай нягт хамтран ажиллаж байгаа талаараа шинээр тусгай зөвшөөрөл авч буй аж ахуйн нэгж, байгууллагуудын төлөөллүүдэд танилцуулан тэдний санал бодлыг сонсон цаашид үйл ажиллагаандаа тусган ажиллахаа МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Б.Батсүх онцолсон юм. Мөн шинээр барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авч буй аж ахуйн нэгжийн төлөөлүүдэд гэрчилгээг нь гардуулан өглөө.

АЖЛЫН АЛБАНЫ БҮАТЗХ-ИЙН “НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ”-ИЙН ТОЙМ


БҮАТЗ-ийн хэлтэс нь “Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр дамжуулан 600 гаруй ААНБ, иргэдийг тухай бүр нь мэдээллээр ханган ажиллав.





БҮАТЗ-тэй холбоотой “Барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, барилгын ажлыг гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, тэдгээрт хяналтыг тавих, барилгын үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудад тавих шаардлага, бүртгэх журам”-ын дагуу барилгын тусгай зөвшөөрлийг хүссэн 174 ААНБ-ын

хүсэлт, материалыг баталгаажуулж, ХББОСЯ-нд 2025.01.02, 2025.01.09, 2025.01.16, 2025.01.23, 2025.01.30-ны өдрүүдэд тус тус цахимаар илгээв.



Тайлангийн хугацаанд давхардсан тоогоор 395 ААНБ-ын хүсэлт хянагдаж, 5 удаагийн БАТАЛГААЖУУЛАЛТ-аар 174 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулав. Үүнээс: Сунгалтаар 10, Нэмэлтээр 41, Шинээр 120, Дахин олгохоор 3 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулав. Сунгалтаар 10 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулснаас: Барилга угсралтаар 10, Нэмэлтээр 41 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулснаас: Барилга угсралтаар 33, Зураг төсөл боловсруулалтаар 8, Шинээр 120 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулснаас: Барилга угсралтаар 102, Зураг төсөл боловсруулалтаар 13, Өргөх байгууламжаар 2, Дахин олгохоор 3 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулснаас: Барилга угсралтаар 2, Зураг төсөл боловсруулалтаар 1 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулав. Эдгээр 5 удаагийн хурлаар давхардсан тоогоор 192 ААНБ-ын материалыг шаардлага хангаагүйн улмаас буцааж, 29 ААНБ-ын хүсэлтийг шалгахаар хүлээгдэж байна.

- Барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, барилгын ажлыг гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, тэдгээрт хяналтыг тавих, барилгын үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагад тавих шаардлага, бүртгэх журам”-ын дагуу тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт ирүүлсэн 174 ААНБ-ын хүсэлтийн материалыг хянаж, 1020 инженер, техникийн ажилтнуудын баталгаажуулалтыг хийв.
- Монгол Улсын Засгийн газрын “Нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал”-д нийтлэх БҮАТЗ-ийг эзэмшигч хуулийн этгээдийн мэдээллийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гаргаж, 3 удаа ХББОСЯ-нд хүргүүлэв. Улсын бүртгэлийн ерөнхий газрын *opendata.burtgel.gov.mn*-д БУ: 4,362, ЗТ: 869, ӨБ: 160 ААНБ-ын нийт 5,391 ААНБ-ын мэдээллийг нээлттэй байршуулав.
- БҮАТЗ-тэй ААНБ-уудын мэдээллийн санг үүсгэн *www.mcis.gov.mn*-ын “Холбогдох бичиг баримт хэсэг”-т БУ: 4,362, ЗТ: 869, ӨБ: 160 ААНБ-ын нийт 5,391 ААНБ-ын мэдээллийг нээлттэй байршуулав.
- Цахим Хөгжил, Харилцаа Холбооны Яам (ЦХХХЯ)-ны тусгай зөвшөөрлийн цахим системд БУ: 104, ЗТ: 20, ӨБ-1 ААНБ-ын мэдээллийг илгээв.
- ХББОС-ын Сайдын тушаалыг үндэслэн 156 ААНБ-тай гэрээг байгуулж, Засгийн газрын “Улсын тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг тогтоох” тогтоолын дагуу 153,400,000 төгрөгийн Улсын тэмдэгтийн хураамжийг Худалдаа, хөгжлийн банкны дансанд төвлөрүүлэв.
- Үйлчилгээний хөлсний 174 ААНБ-ын 102,590,000 төгрөгийг Худалдаа, хөгжлийн банкны 431006029 тоот дансаар төвлөрүүлэн ажиллав.
- ХББОС-ын Сайдын 2025.01.14-ний өдрийн тушаал №05, 2025.01.16-ны өдрийн тушаал №12, 2025.01.24-ний өдрийн тушаал №28, №29 дүгээр тушаалыг үндэслэн 125 ш үнэт цаасанд бичилтийг хийж, баталгаажуулав.

2025

СУРГАЛТ, ХӨГЖИЛ





МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР 15141,
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, 5-Р ХОРОО, САМБУУГИЙН ГУДАМЖ
МН ТАУЭР, 8-Р ДАВХАР
WWW.MNCA.MN

ГИШҮҮН БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГУУДАД “БИЗНЕСИЙН СТРАТЕГИА ШИНЭЧЛЭХ НЬ” СЭДВЭЭР СУРГАЛТЫГ ХИЙЛЭЭ









МБҮА ТББ-ын Гишүүн компаниудын удирдах ажилтнуудад зориулсан “Бизнесийн стратегиа шинэчлэн, OGSM аргаар төлөвлөх нь” сэдэвт сургалтыг Ганабелл Институт-тэй хамтран зохион байгууллаа. Сургалтаар залуу бизнесмэнүүдэд уламжлалт арга барилаас гадна үйл ажиллагаа, бизнесээ явуулахад юун дээр амжилт гаргаж хаана алдаа гарч байна вэ гэдгээ ахин нэг шинжлэн судлахын тулд дэлхийд нэртэй олон компаниудын алдаа, оноо, амжилт, дампуурлын жишээн дээр тулгуурлан тайлбарлалаа. Мөн компани тань нэг л урагшлахгүй, үйл ажиллагаа, борлуулалт тань санасанаар тань болохгүй байгаа бол стратегиа ахин шинэчлэн, OGSM аргаар төлөвлөөд үзэх, тодорхойлох, төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх арга барилын талаар Ганабелл Институтын багш Т.Амарсанаа онол болоод бодит кейс дээр тулгуурлан заалаа.

БАРИЛГЫН САЛБАРТ ФИДИК-ИЙН ГЭРЭЭГ НУТАГШУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ЭЭЛЖИТ СУРГАЛТЫГ ХИЙЛЭЭ



МБҮА ТББ нь Олон Улсын Зөвлөх Инженерүүдийн Холбоо (ФИДИК)-нд ТҮНШЛЭГЧ ГИШҮҮН-ий хувьд Монгол Улсын барилгын салбарт олон улсын гэрээ, эрх зүйн орчныг стандартын дагуу хэрэгжүүлэх, шинэ дэвшил, эргэлтийг авчрах таатай нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2025.01.23-ны өдөр салбарын мэргэжилтнүүдэд барилгын төслийн гэрээ ФИДИК-ИЙН ЖИШИГ ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ-үүд сургалтыг зохион байгууллаа. Уг сургалтад төр болоод хувийн хэвшлийн салбарын инженерүүд, хуульчид, захирлууд оролцсон бөгөөд ФИДИК буюу Олон улсын Зөвлөх Инженерүүдийн Холбоо, түүний үйл ажиллагааны тухай, ФИДИК-ийн жишиг гэрээнүүд, тэдгээрийн ялгаа, жишиг гэрээнээс хэрхэн сонгох тухай, өргөн хэрэглэгддэг Улаан, Шар болон Мөнгөлөг гэрээнүүдийн ялгаа, ФИДИК гэрээний бүтэц, Тусгай нөхцөл бэлтгэх зааварчилгаа, Алтан зарчим, Гэрээний талууд, тэдгээрийн эрх үүрэг, хариуцлагын зохицуулалт, Захиалагч, Инженер, Гүйцэтгэгчийн эрх, үүрэг, хариуцлага, Ажил эхлүүлэх, хойшлох, түр зогсоох, гэрээ цуцлах зохицуулалтууд, Ажил гүйцэтгэх явцын зохицуулалтууд, Гэрээний үнэ, төлбөр, баталгаа, даатгал, Зураг төсөл, дундын болон

эцсийн туршилт, ажлыг хүлээж авах, Маргаан шийдвэрлэлтийн талаарх ойлголтыг авлаа. Мөн сургалтад суусан инженерүүдэд мэргэжил дээшлүүлэх хоёр багц цаг олгож сертикафат гардууллаа.

Сургалт, зохион байгуулалтын чиглэлээр:

- МБҮА ТББ-ын Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэхтэй холбоотой Ажлын албаны ажилчдын өгсөн саналуудыг нэгтгэн хуульчид шилжүүлж өгсөн.
- 2025.02.13-ны өдөр МБҮА ТББ-ын анхдугаар Удирдах Зөвлөлийн хурал товлогдсонтой холбоотой хурлыг зохион байгуулах ажлын хэсгийн тушаалын төслийг боловсруулж Гүйцэтгэх захирлын 2025.01.06-ны өдрийн А-25/01 тоот тушаалаар батлуулсан. Дээрх ажлын хэсгийн ахлагчаар томилогдон ажиллаж байна. Ажлын хэсэг одоогийн байдлаар хурал зохион байгуулагдах танхимын захиалгыг өгсөн, хурлаар хэлэлцэх асуудлуудын жагсаалтыг гаргаж Гүйцэтгэх захиралд өгсөн. Хурлаар хэлэлцэгдэх дүрэм, журмын төслүүдийг холбогдох ажилчид боловсруулан, дотооддоо хэлэлцүүлэн ажиллаж байна.
- 2025.01.15-ны өдөр МБҮА ТББ-ын гишүүн компаниудын удирдах ажилтнуудад зориулсан “Бизнесийн стратегиа шинэчлэн, OGSM аргаар төлөвлөх нь” сэдэвт сургалтын зохион байгуулалтыг хариуцан ажиллаж сургалтад нийт 24 ААНБ-ын удирдлагуудыг хамруулсан.
- 2025.01.23-ны өдөр “Барилгын төслийн Фидикийн жишиг гэрээ” сэдэв сургалтыг зохион байгуулж, сургалтад нийт 61 иргэн, ААНБ, барилгын инженер, төрийн албан хаагч, өмгөөлөгчид, олон улсын байгууллагын төлөөлөл оролцож Гэрчилгээ гардуулж өгсөн.
- Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх А3 сургалт явуулдаг албан газруудыг судалж Ажлын албаны албан хаагчдыг хамруулахаар ажиллаж байна.

Оффисын үйл ажиллагааны хүрээнд:

- МБҮА ТББ-ын оффисын өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн, тогтвортой явуулах нөхцөлийг бүрдүүлж, удирдлага болон ажилтнуудыг шаардлагатай мэдээ мэдээллээр ханган ажиллав.
- МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирлын өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн, зохион байгуулж ажиллах орчныг хангаж ажиллав.
- МБҮА ТББ-ын АЖлын албаны мэйлд ирсэн мэдээллийг Гүйцэтгэх захирал болон холбогдох албан тушаалтанд хуваарилан илгээж ажиллалаа.
- Захирал болон АА-ны ажилчдын олон нийтэд чиглэсэн үйл ажиллагааны бэлтгэлийг хангаж, уулзалтын календарчилсан төлөвлөгөө гаргаж, оролцох шаардлагатай үйл ажиллагааг тодруулж ажиллаа.
- МБҮА ТББ-ын Ажлын албанд шинээр орсон ажилчдыг мэдээллээр ханган, шаардлагатай тоног төхөөрөмж болон бичиг хэргийн эд зүйлсийг хүлээлгэн өгч, эд хөрөнгийн жагсаалт гарган хүлээлгэж өгч ажиллалаа.
- МБҮА ТББ-ын Ажлын албаны Эд хөрөнгийн тооллогыг хийж, актлах эд хогшлыг бүртгэж, актлах үйл ажиллагааны бэлтгэлийг хангаж ажиллалаа.
- МБҮА ТББ-ын Ажлын албаны ажилчдын ажлын цагийн бүртгэлийг 15 хоногоор шивж, баталгаажуулан албажуулж ажиллалаа.
- МБҮА Тбб-ын Ажлын албаны 2022-2024 оны бичиг хэргийн архивлалтыг хийж, 2025 оны бичиг хэргийн бэлтгэл ажлыг хангаж ажиллалаа.

Албан бичгийн хүрээнд:

Тайлан гаргасан **С.Уянга** [Оффис менежер] 2025/01/27 Даваа гариг 15:17 Хэвлэх MS-Excel MS-Word

Эхлэл **2025/01/01** Лхагва гариг
Төгсгөл **2025/01/27** Даваа гариг
Нийт урт Хуанлийн **27** өдөр

ИРСЭН БИЧГИЙН НЭГТГЭЛ ТАЙЛАН
[Хүлээн авсан огноогоор]

Дэлгэцэнд **6** ирсэн бичиг
Төрөл Нэр дээр байгаа бичгүүдийн тайлан

Салбар хэлтэс	Бүгд	Хуудас	Хариутай					Хариугүй		Байгууллагад эзлэх хувь
			Нийт	Шийдвэр-лэсэн	Шийдвэр-лэлтийн хувь	Хяналтанд байгаа	Хугацаа хэтэрсэн	Нийт	Шийдвэр-лэсэн	
Удирдах ажилтнууд	0	0	0	0	0	0	0	0	0	0
МБҮА ТББ (МБҮА)	0	0	0	0	0	0	0	0	0	0
Ажлын алба (ГЗ)	6	8	4	2	50%	2	0	2	0	100%
Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хэлтэс (БҮАТЗХ)	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бусад байгууллагын хяналтанд байгаа бичгүүд	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бүгд	6	8	4	2	50%	2	0	2	0	100%

Тайлан гаргасан **С.Уянга** [Оффис менежер] 2025/01/27 Даваа гариг 15:03 Хэвлэх MS-Excel MS-Word

Эхлэл **2025/01/01** Лхагва гариг
Төгсгөл **2025/01/27** Даваа гариг
Нийт урт Хуанлийн **27** өдөр

ЯВСАН БИЧГИЙН НЭГТГЭЛ ТАЙЛАН
[Илгээсэн огноогоор]

Төрөл **Явсан бичгийн тайлан**

Илгээгч салбар хэлтэс	Нийт	Хуудас	Хариутай	Хариу авсан	Хугацаа хэтэрсэн	Бүрэн хүлээн авсан	Огт хүлээн аваагүй	Системийн байгууллагад илгээсэн	Нийт бичгийн байгууллагад эзлэх хувь
Ажлын алба (ГЗ)	21	87	14	5	0	0	0	0	100%
Дүн	21	87	14	5	0	0	0	0	100%

Хэвлэсэн **С.Уянга** [Оффис менежер] 2025/01/27 Даваа гариг 16:26 Хэвлэх MS-Excel MS-Word

Эхлэл **2025/01/01** Лхагвагариг
Төгсгөл **2025/01/27** Даваа гариг
Нийт Хуанлийн **27** өдөр

НИЙТ ГЭРЭЭ

Дэлгэцэнд **4** гэрээ

№	Дугаар	Харилцагч	Гэрээний гарчиг	Төлбөр	Нөгөө талаас	Манай талаас	Сунгалт	Алданги	Гүйцэтгэлийн баталгаа	Огноо		Хэлбэр	
									Дуусах өдөр	Эхлэх	Дуусах	Ангилал	Хаагдсан эсэх
1	АГГ-25/01	Дижитал мөүшин ХХК	Ажил гүйцэтгэх гэрээ	2'854'000.00	Б.Тэмүүжин	G.Batsukh	[?]	[?]	[?] 0	25/01/06	25/01/21	Энгийн гэрээ [Ажил гүйцэтгэх]	Хаагдаагүй
2	АГГ-25/03	Барилгын сургалт, хөгжлийн академи НҮТББ	"Барилгын төслийн ФИДИК-ийн жишиг гэрээ" сургалт	5'080'000.00	С.Оргилцэцэг	Г.Батсүх	[?]	[?]	[?] 0	25/01/22	25/01/23	Энгийн гэрээ [Ажил гүйцэтгэх]	Хаагдсан
3	АГГ-25/04	МУИС ШУС-ийн социологи, нийгмийн ажлын тэнхим	Сургалтын гэрээ	800'000.00	Т.Бүрэнжаргал	G.Batsukh	[?]	[?]	[?] 0	25/01/15	25/01/16	Энгийн гэрээ [Ажил гүйцэтгэх]	Хаагдсан
4	АГГ-25/05	ШУТИС-ийн Барилга архитектурын сургууль	Сургалтын гэрээ	800'000.00	Б.Лхагвадулам	G.Batsukh	[?]	[?]	[?] 0	25/01/15	25/01/16	Энгийн гэрээ [Ажил гүйцэтгэх]	Хаагдсан

Монголын барилгын үндэсний ассоциаци

© 2025 Able Software

2025

ГИШҮҮНЧЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА



МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР 15141,
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, 5-Р ХОРОО, САМБУУГИЙН ГУДАМЖ
МН ТАУЭР, 8-Р ДАВХАР
WWW.MNCA.MN

МБҮА ТББ-ын Гишүүнчлэлийнхээ тоог нэмж, үйл ажиллагааныхаа цар хүрээг тэлэх зорилт, 2025 онд хэрэгжүүлэх Гишүүнчлэлийн төслийн хүрээнд гишүүнчлэлийн бүтээгдэхүүн үйлчилгээг олон нийтэд таниулан хүргэхээр мэдээлэл постер бэлтгэн холбогдох мэдээ мэдээллийг өгч ажилласны үр дүнд 2025.01-р сард Дэд гишүүнээр барилга угсралт, бусад цахилгаан инженеринг болон угсралтын ЭНХ ӨРНӨХ ЭХЛЭЛ КОНСТРАКШН ХХК, МАКСИМАЛ ХХК, Ажиглагч гишүүнээр ТУУРАЙН ТАМГА ХХК, САБСТРУКТУР ИНЖЕНЕРИНГ ХХК, УГТАХ БЕСТ, ОРГИЛ ЦАМХАГ КОНСТРАКШН ХХК нь гишүүнээр элслээ.

MaXimal
RAILWAY DESIGN, PLANNING AND ENGINEERING TECHNOLOGICAL CONSULTING SERVICE





Гишүүн байгууллагад үйлчлэх бүтээгдэхүүн үйлчилгээний жагсаалтыг зурагжуулан, байгууллагын пэйж-д товч мэдээллийн хамт байршуулаа. Гишүүдийн үйл ажиллагааг дэмжих, тэдгээрийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, идэвх оролцоог дэмжихэд чиглэгдсэн урамшууллын тогтолцоог бий болгох, гишүүнчлэлийн татварыг төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулах ЖУРАМ-ын төслийг боловсруулан МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал болон холбогдох удирдлага менежерүүдэд танилцуулав.

Гишүүн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор олон улсад зохион байгуулагдаж буй барилгын салбарын шинэ техник, технологитой танилцах бизнес-аяллыг жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг бөгөөд 2025 оны эхний бизнес-аяллын **KOREA BUILD WEEK-2025** үзэсгэлэнгийн зар, постер мэдээллийг бэлтгэн хүргэв.

МБҮА ТББ-ын Ажлын албаны зүгээс 2025 онд тусгагдсан төлөвлөгөөт гишүүдэд болон олон нийтэд чиглэгдсэн ажлуудыг идэвхжүүлэх зорилгоор дараах постер мэдээллийг бэлтгэн хүргэв.





“Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хүсэлтийг цахимаар хэрхэн ирүүлэх талаар заавар зөвлөгөө” - цахим сургалт

МБҮА ТББ-ын гишүүн компаниудын удирдах ажилтнуудад зориулсан “Бизнесийн стратегиа шинэчлэн, OGSM аргаар төлөвлөх нь” сэдэвт сургалт







Гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр:

- Гадаад харилцаа, хамтын ажиллагаатай холбоотой өдөр тутмын захидал харилцааны foreign_relations@mnca.mn хаягаар ирсэн 8 цахим шууданг орчуулан удирдлагад танилцууллаа. Мөн хаягаар 5 захидлыг гадагш илгээсэн.
- 2025 оны гадаад арга хэмжээний Төлөвлөгөөний төсөл бэлтгэн удирдлагад танилцуулав. Энэ хүрээнд нийт 13 арга хэмжээний талаарх товч мэдээлэл, оролцогчийн зардлын тойм тооцоог хийж бэлтгэсэн.
- IFAWPCA-гийн 47-р их хуралд оролцох МБҮА ТББ-ын Ерөнхийлөгчийн бүртгэлийг хийж, нислэгийн тийзийн төлбөрийг шилжүүлж, баталгаажуулаа.
- Гадаадын ассоциациудтай байгуулсан “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийн шинэчлэх санал бэлтгэлээ.
- СЭЗИС-тай байгуулсан Хамтын ажиллагааны санамж бичигт заасны дагуу Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ-ын дүрмийг шинэчлэн бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлж батлуулахтай холбоотойгоор ажлын хэсгийн боловсруулсан дүрмийн шинэчилсэн найруулгын төсөлд санал авахаар хүргүүлэв.

2025

“ДУЛААН ШИЙДЭЛ2" төсөл



МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР 15141,
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, 5-Р ХОРОО, САМБУУГИЙН ГУДАМЖ
МН ТАУЭР, 8-Р ДАВХАР
WWW.DULAALGA.MN

ТӨСЛИЙН ДУЛААЛГЫН ЗӨВЛӨХҮҮДИЙН 2024 ОНЫ СҮҮЛИЙН ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ДАГУУ ҮНЭЛЛЭЭ

Төсөлтэй хамтран ажиллаж буй дулаалгын зөвлөхүүдийн 2024.6-11 дүгээр сарыг дуустал буюу жилийн сүүлийн хагасын ажлын гүйцэтгэлийг техникийн үнэлгээ, дулаалгын ажлын гүйцэтгэл болон чанарын хяналт, хэрэглэгчдийн сэтгэл ханамж, идэвх оролцоо гэсэн 3 багц, нийт 11 шалгуур үзүүлэлтээр үнэллээ. Энэхүү шалгуур үзүүлэлтийн босго нь сард 2 ба түүнээс дээш айл өрхийн байшингийн дулаан алдагдлыг илрүүлсэн байх юм. Тайлант хугацаанд энэхүү босгыг давсан 16 дулаалгын зөвлөх байгаа бөгөөд эдгээр зөвлөхүүд нийтдээ 132 айл өрхийн байшингийн дулаан алдагдлыг илрүүлж, үүнээс 21-д нь дулаалга хийсэн байна. Тухайлбал нийт 6 сарын хугацаанд 13 айл өрхийн байшингийн дулаан алдагдлыг илрүүлж, үүнээс 6 айл өрхөд дулаалга хийсэн гүйцэтгэлээрээ Ш.Баярсайхан тэргүүлж, дулааны камераар шагнуулах болзол хангалаа. Нийт нийлбэр оноогоор эхний 5-д жагссан бусад дулаалгын зөвлөхийг барилгын багажаар урамшуулах болно.

"Дулаан шийдэл-2 төсөл"-тэй хамтран ажилладаг барилгын салбарын бизнес эрхлэгчдийн хагас жилийн ажлын гүйцэтгэлийн нэгтгэл /2024.06-2024.11-р сар/
Semi annual KPI score of Project MSMEs of the SOAPII /June 2024-Nov 2024/

Д/д	Дулаалгын зөвлөх/ Бригадын ахлагчийн нэр/Name of EA and Brigade Leaders	2024 оны 6-р сар/June 2024	2024 оны 7-р сар/July 2024	2024 оны 8-р сар/August 2024	2024 оны 9-р сар/Sep 2024	2024 оны 10-р сар/Oct 2024	2024 оны 11-р сар/Nov 2024	Нийт оноо/Total score	Бонус оноо / Bonus points (Нэг сарыг 3 оноогоор	Нийт нийлбэр оноо/ Total score
		Оноо/Score	Оноо/Score	Оноо/Score	Оноо/Score	Оноо/Score	Оноо/Score			
1	Ш.Баярсайхан/Sh.Bayarsaikhan	57.5		61	95.5	91.9		305.9	12	317.9
2	Ц.Гаябазар/Ts.Gayabazar	49.4	53.3	34.9	52.4	50.4	52.3	293	18	311
3	Т.Базар/T.Bazar		72.8		45.9	70.1	59.5	248.3	12	260.3
4	Ж.Есүхэй/J.Esukhei	58.4	37.4	51.3	53.5	32.8		233	15	248
5	Ц.Цогт-Эрдэнэ/Ts.Tsogt-Erdene		54,3	74.5	59	47		234.8	12	246.8
6	Ц.Пүрэв/Ts.Purew	72.8				68.5	57.5	199	9	208
7	Л.Цэвэрэгзэн/L.Tseyeregzen	54			53		57.6	165	9	174
8	О.Эрдэнэхүү/O.Erdenekhuu				49.1	39	54	142,1	9,0	151,1
9	Д.Нямгэрэл/D.Nyamgerel	53.2	55					108.2	6	114.2
10	Н.Баярсайхан/N.Bayarsaikhan			50.5	52.9			103	6	109
12	Г.Оргилмаа/G.Orgilmaa			48.4	45			93.4	6	99.4
13	Ч.Сумъяабат/Ch.Sumiyabat	69,5						69,5	3	72.5
14	Л.Түвшинжаргал/L.Tuvshinjargal						54.6	54,6	3	57.6
15	О.Минжмаа/O.Minjmaa						52.3	52.3	3	55.3
16	Б.Баттулга/B.Battulga				49.4			49.4	3	52.4
	Дундаж/ Average	59.25	54.56	53.43333333	55.57	57.1	55.4	138	6.818181818	131

БАРИЛГЫН САЛБАРЫН ААНБ, БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ЧАДАВХЖУУЛАХ БАГЦ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД 4 ТӨРЛИЙН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЖ, 72 ХҮНИЙГ ХАМРУУЛАВ

“ДУЛААЛГЫН ӨРТӨГ ТООЦООЛОЛ, НОГООН ЗЭЭЛ, ДУЛААЛГЫН ПЛАТФОРМ” СУРГАЛТ:






Огноо: 2025.01.22
Зохион байгуулагч: МБҮА ТББ, Жэрэс ОУТББ, ШУТИС-ийн дэргэдэх БЭХХТ
Хамрагдсан хүний тоо: 14
Эзэмшүүлсэн мэдлэг, мэдээлэл: Дулаалгын зах зээлийн загвар, дулаалгын үнэлгээ, өртөг тооцоолол гаргах аргачлал, дулаалгын ногоон зээлийн тухай, “Дулаан шийдэл” вэб системийн зааварчилгаа гэх мэт
Байршил: ШУТИС-ийн дэргэдэх Барилгын эрчим хүч хэмнэлтийн төв

Дээврийн дулаалгын материалын үнэ (2025 оны 1 дүгээр сарын 15-ны байдлаар)		
Нийлүүлэгч	**Материалын нэр**	**М2 ҮНЭ 15см**
Эковүүл ХХК	Ноосон дулаалга	23,280
Росторг	Эрдэс хөвөн-15см Росторг	30,850
Росторг	Эрдэс хөвөн (Экоролл Росторг)	17,100
Базалт	Чулуун хөвөн (Basaltwool)	24,300
Росторг	Эрдэс хөвөн хавтгай 0.40 (Knauf Росторг)	24,600
Росторг	Эрдэс хөвөн хавтгай 0.37 (Knauf Росторг)	30,750
Гэгээн өргөө ХХК	Америк эрдэс хөвөн	36,000
Ханын дулаалгын материалын үнэ		
Нийлүүлэгч	**Материалын нэр**	**М2 ҮНЭ**
Пирамид индастри ХХК	EPS хөөсөнцөр хавтан	45,000
Кунаф ХХК	EPS хөөсөнцөр хавтан	35,000
Эковуул ХХК	Ноосон дулаалга	35,250
Росторг	Эрдэс хөвөн (Экоролл Росторг)	17,820
Базалт	Чулуун хөвөн (Basaltwool)	35,745
Росторг	Эрдэс хөвөн хавтгай 0.40 (Knauf Росторг)	22,500
Росторг	Эрдэс хөвөн хавтгай 0.37 (Knauf Росторг)	25,965
Цонхны дулаалга материалын үнэ		**М2 ҮНЭ**
Стар виндов	Цонх 3 давхар шилтэй, энгийн онгойлттой	390,000
Стар виндов	Цонх 3 давхар шилтэй, хос онгойлттой	420,000
Стар виндов	Герман цонх 3 давхар шилтэй, энгийн онгойлттой	550,000
Стар виндов	Герман цонх 3 давхар шилтэй, хос онгойлттой	600,000
Шалны ба суурийн дулаалга материалын үнэ		**М2 ҮНЭ**
Росторг	XPS нягт хөөсөнцөр (10см)	38,600

“МАРКЕТИНГ, БОРЛУУЛАЛТ” СУРГАЛТ:







Огноо: 2025.01.22
Зохион байгуулагч: МБҮА ТББ, Жэрэс ОУТББ
Хамрагдсан хүний тоо: 10
Эзэмшүүлсэн мэдлэг, мэдээлэл: Зах зээлд суурилсан төсөл гэж юу вэ? Төслийн маркетингийн сувгууд, “Дулаан шийдэл” төслийн бүтээгдэхүүн үйлчилгээ, дулаалга хийхэд тулгардаг асуудлууд, төслийн онцлог давуу тал, амжилттай борлуулалт хийх аргачлал- амжилттай борлуулалт хийхийн тулд хэрэглэдэг 5 шатлалд арга, кэйс ажиллагаа-хэцүү хэрэглэгчтэй хэрхэн харилцах талаар ойлголт.
Байршил: ШУТИС-ийн дэргэдэх Барилгын эрчим хүч хэмнэлтийн төв

"БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ" СУРГАЛТ:





Огноо: 2025.01.23
Зохион байгуулагч: МБҮА ТББ
Хамтран зохион байгуулагч: ШУТИС-ийн Барилга архитектурын сургууль
Хамрагдсан хүний тоо: 27
Эзэмшүүлсэн мэдлэг, мэдээлэл: Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулах, хог хаягдлыг ангилах, дахин ашиглах, дахин боловсруулах тухай
Байршил: ШУТИС-ийн дэргэдэх БЭХХТ, Хог хаягдлын тухай хууль болон Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журамтай доорх холбоосоор орж танилцана уу.
https://legalinfo.mn/mn/detail/12652 https://legalinfo.mn/mn/detail?lawId=210761&showType=1 Тус сургалтад МБҮА ТББ-ын гишүүн 7 байгууллагын 12 хүн хамруулав. Үүнд, Эко констракшн ХХК, Эй Жи Жи Эс ХХК, Цагаан уран хийц ХХК, Түм арвижих ХХК, БХЯ-ны Барилга захиалагчийн алба, Заг инженеринг групп ХХК, Жигүүр гранд групп ХХК, И Си Си ХХК, БҮТИ ХХК

“БАРИЛГЫН САЛБАР ДАХЬ ЖЕНДЭРИЙН АСУУДАЛ, ШИЙДЭЛ” СУРГАЛТ:







Огноо: 2025.01.23
Зохион байгуулагч: МБҮА ТББ
Хамтран зохион байгуулагч: Нийгмийн бодлого хөгжлийн судалгааны хүрээлэн
Хамрагдсан хүний тоо: 21
Эзэмшүүлсэн мэдлэг, мэдээлэл: Жендэрийн үндсэн ойлголт, Хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдал, Барилга, хот байгуулалтын салбарт жендерийн талаар баримтлах бодлого, Барилгын салбарын бизнес эрхлэгчдэд тулгардаг жендэрийн асуудал, шийдвэрлэх арга зам
Байршил: ШУТИС-ийн дэргэдэх Барилгын эрчим хүч хэмнэлтийн төв

"Барилгын салбарт жендэрийн талаар баримтлах бодлого" болон "Ажиллагсдын ажлын орчин нөхцөлийн жендэрийн мэдрэмжийг үнэлэх тоон болон чанарын багц шалгуур үзүүлэлт болон ажилчдын байрны шалгах хуудас"-тай доорх холбоосоор орж танилцана уу. https://mcud.gov.mn/p/62, https://mcud.gov.mn/resource/mcud/File/2024/10/30/5i7ts1wzz614i66q/20241030%20gender.pdf

“БОДЬ ПРОПЕРТИЙЗ” ХХК-ИЙН САНХҮҮЖИЛТЭЭР БҮТЭН ДУЛААЛГА ХИЙХ 2 АЙЛЫГ СОНГОЛОО













Нийгмийн хариуцлагын хүрээнд “Бодь Пропертийз” ХХК-ийн санхүүжилтээр Улаанбаатар хотод амьдарч буй 2 айл өрхийн байшинг бүтэн дулаалах болж, нээлттэй шалгаруулалтыг 2024.11-р сард зарлаж нийт 22 айл материалаа ирүүлсэн. Эдгээр айл өрхийг 12 шалгуур үзүүлэлтээр үнэлж, хамгийн өндөр оноо авсан эхний 10 айлд камертай хэмжилт үнэ төлбөргүй хийж гүйцэтгэсэн юм. Өөрөөр хэлбэл байшингийн бодит хэмжилтийг хийж, гадна, дотор агаарын температур, чийгшлийг хэмжин, дулааны камераар байшингийн дотор, гадна талын дулаан алдагдлыг илрүүлж, технологийн дагуу дулаалга хийх боломжтой эсэх, тийм бол ямар төрлийн дулаалга хийх боломжтой, ямар үнэ өртгөөр хийхийг тооцоолж, айл өрхүүдэд зөвлөгөө өгсөн юм. Ингээд 3 айлыг богино жагсаалтад оруулж 2025.01.21-нд төслийн багийнхан эдгээр байшинтай очиж танилцан, байшингийн ханын бүтцийг нарийвчлан тодорхойлж, дээврийн өнгийлтийг шалган, дулаалга хийх болон сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж суурилуулах боломжтой эсэх, агаарын бохирдол ихтэй бүсэд амьдарч байна уу гэх мэт байдлыг нягталлаа. Үүний үр дүнд СХД, 7-р хороо, Баянхошуунд оршин суух иргэн Б.Үрлээ болон СХД-ийн 22-р хороо, Хилчин 34-р гудамжинд оршин суух иргэн Г.Хүрэлбаатарын байшинг тус тус бүтэн дулаалж, хамтарсан төслийн хүрээнд сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж суурилуулахаар сонголоо. Энэ үеэр сонгогдсон 2 айл өрхийн байшинд дулаалахаас өмнөх дулааны тав тух болон дотор агаарын чанарыг хэмжих зориулалт бүхий өвлийн хэмжилтийн багажийг суурилуулав. Ингэснээр дулаалсан болон сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж суурилуулсны дараа ямар өөрчлөлт гарч байна вэ гэдгийг харьцуулах юм. Тодруулбал, энэхүү өвлийн хэмжилтийн багаж нь байшингийн дотор агаарын температур, чийгшлийг хэмждэг. Чийгшлийг хэмжинэ гэдэг нь агаар сэлгэлт явагдаж байна уу, үгүй гэдгийг илэрхийлнэ. Тухайн айл өрхийн дулааны тав тухыг илэрхийлэгч нь дотор агаарын температур юм. Ийнхүү өөр дээрээ санах ойтой, 2 жил хүртэл хугацаанд мэдээллээ өөртөө хадгалж байдаг тул судалгааны ажилд зориулсан багаж юм. Бусад төрлийн өвлийн хэмжилтийн багаж буюу дотор агаарын чанар хэмжигч багажийг доор зургаар харуулав. Мөн энэ үеэр аж ахуйн аргаар иргэд өөрсдөө барьж дулаалсан байшинд тулгардаг түгээмэл асуудлын талаар төслийн дулаалгын зөвлөхүүд олон нийтэд хандан мэдээлэл, зөвлөгөө өглөө. Та бүхэн, “Бодь Пропертийз” ХХК-тай хамтран хэрэгжүүлж буй “Дулаан байшин, тухтай амьдрал” төслийн явцын тайлантай танилцахыг хүсвэл доорх холбоосоор хандаарай.
https://drive.google.com/drive/folders/180PN0DiDrNBOD7jFeooomlM5oHrGACpt?usp=drive_link

БАРИЛГЫН САЛБАРЫН БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН 4 СУРГАЛТАД 10 ГАРУЙ ДУЛААЛГЫН ЗӨВЛӨХИЙГ ХАМРУУЛЛАА





2025.01.07-нд Ногоон барилгын хүрээлэнгээс зохион байгуулсан Ногоон барилгын үнэлгээний аргачлал, гэрчилгээжүүлэх журмын танилцуулах, 2025.01.15, 01.17-нд МБҮА ТББ-аас зохион байгуулсан “Бизнесийн стратегиа шинэчлэн, OGSM аргаар төлөвлөх нь”, Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хүсэлтийг цахимаар хэрхэн ирүүлэх талаар заавар зөвлөгөө, 2025.01.16-нд Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Авлигын эсрэг хууль тогтоомжийг тайлбарлан таниулах” сургалт тус тус "Дулаан шийдэл II" төсөлтэй хамтран ажиллаж буй 10 гаруй

дулаалгын зөвлөхийг хамруулаад байна. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 108 дугаар тушаалаар батлагдсан "Ногоон барилгын үнэлгээ (BestGER)-ний аргачлал"-ыг дараах холбоосоор татаж авч, танилцана уу. https://mcud.gov.mn/a/1522

ӨНГӨРСӨН ОНД ГАРГАСАН ГОЛ ҮР ДҮНГҮҮДЭЭ ТАНИЛЦУУЛЛАА



2025.01.21-нд болсон төслийн хэрэгжүүлэгч байгууллагуудын уулзалтаар МБҮА ТББ-ын Дулаан шийдэл II төслийн багийн 2024 онд гаргасан гол үр дүнгүүдээ танилцууллаа. Үүнд:

- Улаанбаатар болон Дархан-Уул аймгийн нийтдээ 500 айл өрхийн байшингийн дулаан алдагдлыг илрүүлж, 246 айл өрхөд дулаалга хийв.
- Барилгын салбарынханд зориулж 30 сургалт, арга хэмжээ зохион байгуулж, давхардсан тоогоор 794 хүнийг хамруулсан байна.
- Төслийн ажил гүйцэтгэсэн 38 барилгын бизнес эрхлэгчийг нийтдээ 274 сая төгрөгийн нэмэлт орлого олох боломжоор хангав.
- Улаанбаатар болон Дархан-Уул аймагт нийтдээ 71 дулаалгын зөвлөх бэлтгэсэн.
- Бодь Пропертийз ХХК-ийн санхүүжилтээр “Дулаан байшин, тухтай амьдрал” төсөл хэрэгжүүлж байна.
- “Дулаан шийдэл II” төслийн үйл ажиллагаа Дархан-Уул аймагт тэллээ. Дэлгэрэнгүй тайлантай дараах холбоосоор уншиж танилцах боломжтой. https://drive.google.com/file/d/10x-4o1tTllpjbSLHiyS_Up6TSZUiHX7O/view?usp=drive_link

Нийгмийн хариуцлагын хүрээнд 210 айл өрхийн дээврийг дулаалав.

- Дулаалга, эрчим хүч хэмнэлтийн ач холбогдлын талаар 2.3 сая иргэнд мэдээлэл өгсөн.
- Амины орон сууцны эрх зүйн орчныг бий болгох тухай саналаа салбарын сайдад уламжилсан.
- Барилгын салбарын бизнес эрхлэгчдэд зориулсан "Дулаан шийдэл II" төслийн гарын авлага гаргалаа.
- Хагас жилийн шилдэг гүйцэтгэгчдээ урамшуулав.
- “Спортын нөхөрсөг өдөрлөг”-ийг 2 дахь жилдээ амжилттай зохион байгуулсан юм.

“ДУЛААН ШИЙДЭЛ II” ТӨСЛИЙН БАГИЙН 2025.01-Р САРЫН ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТОЙМ

Д/Д	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ТООН ҮЗҮҮЛЭЛТ
1.	ББЖБЭ-дэд зуучилсан техникийн үнэлгээний захиалга	34
2.	Техникийн үнэлгээний захиалгыг хуваарилсан ББЖБЭ-ийн тоо	13
3.	ББЖБЭ-ийн хийж гүйцэтгэсэн техникийн үнэлгээний тоо	27
4.	ББЖБЭ-дэд зуучилсан дулаалгын ажлын тоо	1
5.	ББЖБЭ-дэд зориулан зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо	5
6.	Зохион байгуулсан сургалт, арга хэмжээнд оролцсон ББЖБЭ-ийн тоо	42
7.	Арга зүйн зөвлөмжийг өгсөн ББЖБЭ-ийн тоо	13
8.	Санал, хүсэлт, гомдлыг нь шийдвэрлэсэн харилцагчдын тоо	5



МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009

Монгол Улс, Улаанбаатар 15141,
Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Самбуугийн гудамж,
МН Тауэр, 8-р давхар, 805, 806, 811 тоот

7011 1515

info@mnca.mn

www.mnca.mn